АГУУЛГА

I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА..... 2
I.1 Төслийн нэр.....2
I.2 Төслийн зорилго 2
I.3 Аж ахуй нэгжийн эрх.....2
I.4 Орд ашиглах тусгай зөвшөөрөл 2
I.5 Төслийн байршил 2
I.6 Ордын нөөц 3
I.7 Уурхайн ажлын горим.....4
I.8 Хүчин чадал 4
I.9 Инженер хангамж, дэд бүтэц бусад хэсэг.....4
I.10 Эдийн засгийн үр ашиг 5
II. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ СУУРЬ НӨХЦӨЛ..... 6
III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ 9
III.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл 9
III.2 Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл 9
III.3 Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....10
III.4 Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....10
IV. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ГОЛ ЗОРИЛТ 12
IV.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө 13
IV.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө 16
IV.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах.....17
IV.4 Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө 18
IV.5 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 18
IV.6 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө 18
IV.7 Хатуу хог хаягдлын менежмент 21
IV.8 Химийн бодис эрсдэлийн менежментийн төлөвлөгөө 22
IV.9 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө 22
IV.10 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь 22
V. 2024 ОНЫ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР 24
VI. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ . 25

I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

I.1 Төслийн нэр

Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших Туулын зүүн дэнж нэртэй алтны шороон орд.

I.2 Төслийн зорилго

Туулын зүүн дэнж алтны шороон ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн үндсэн зорилго нь чулуун алт олборлож, гадаад, дотоод зах зээлд нийлүүлж борлуулахад чиглэнэ.Дээрх төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан хууль эрх зүй, байгаль хамгаалах арга, аргачлалын дагаж мөрдөнө.

I.3 Аж ахуй нэгжийн эрх

“Хамтын эх булаг” ХХК нь Монгол улсын 9011595141 тоот бүртгэлийн дугаар, Ашиглалтын MV-016896 тусгай зөвшөөрөлтэй.

I.4 Орд ашиглах тусгай зөвшөөрөл

Туулын зүүн дэнж алтны шороон ордод анх АМГ-ын ГУУКХ-ийн даргын 2010 оны 04-р сарын 07 өдрийн №397 тоот шийдвэрээр “Хүлэмж” ХХК-д олгосон MV-015552 тоот ашигт малтмал ашиглах ашиглалтын тусгай зөвшөөрлийг хэсэгчлэн буюу 30.71 га талбайг АМГ-ын ГУУКХ-ийн даргын 2011 оны 07-р сарын 29-ний өдрийн №746 тоот шийдвэрээр“Хамтын эх булаг” ХХК-д шилжүүлснээр MV-016896 тоот ашигт малтмал ашиглах ашиглалтын тусгай зөвшөөрлийг шинээр олгосон байна.

I.5 Төслийн байршил

Туулын зүүн дэнж нэртэй алтны шороон орд нь Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос баруун зүгт 240 км, Эрдэнэт хотоос 130 км, Булган аймгийн төвөөс 110 км, Өгөөмөр тосгоноос 4 км тус тус байрладаг.

Ашигт малтмалын үндсэн төрөл: Алт

Талбайн нийт хэмжээ: 30.71 га



Зураг №.1 Төслийн талбайн байршил

Хүснэгт № 1 Талбайн газар зүйн солбицол

Цэг	Зүүн уртраг			Хойд өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	104°	23′	50.4″	48°	19′	14.56″
2	104°	23′	50.33″	48°	18′	55.9″
3	104°	23′	32.93″	48°	19′	1.82″
4	104°	23′	32.93″	48°	18′	41.81″
5	104°	23′	21.93″	48°	18′	41.81″
6	104°	23′	21.94″	48°	19′	6.81″
7	104°	23′	30.94″	48°	19′	6.81″
8	104°	23′	37.94″	48°	19′	6.81″
9	104°	23′	46.94″	48°	19′	15.8″

I.6 Ордын нөөц

Ордын хайгуулын ажлын торын нягтралыг 60.0 м, 140-150x20-40 ийн тороор хангаж нөөцийн бодит В зэрэглэлд хангах боломж бүрдүүлсэн бөгөөд тус ордын тогтоц, хэлбэр ашигт болон хучаас давхаргуудын зузаан, алтны тархалтын ерөнхий зүй тогтол зэргийг одоо тухайн орд дээр явагдаж байгаа ашиглалтын ажлын үзүүлэлттэй уялдуулан тооцсон байна.

Ашиглалтын хайгуулын ажлыг Туул голын зүүн гар талын дэнж дээр байрлах C_2-8 блокийн баруун хойт, баруун хэсэгт гүйцэтгэсэн байна. Хайгуулын ажлын явцад цохилтот өрмийн нийт хайгуулын 7 шугамаар 56 цооног буюу 1938.9 т/м өрөмдөж, шижирмэг алтны нөөцийг бодитой В зэрэглэлээр нөөцийн ангилалд

хамрагдах 112.321 кг, боломжит С зэрэглэлээр 4.386 кг нийт 116.707 кг алт химийн цэврээр тооцсон байна.

I.7 Уурхайн ажлын горим

Уурхай нь жил бүрийн 4-р сарын 10-аас бэлтгэл ажлыг эхлүүлж, 5-р сарын 10-аас 10-р сарын 20 хүртэл хөрс хуулах, элс олборлох, элс угаах, нөхөн сэргээлт хийх болон бусад ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүй 7 хоног, өдөрт 2 ээлжээр 12 цагийн уртасгасан хугацаагаар явагдана.

Үйлдвэрлэлийн бусад ажил болох цахилгаан хангамж, усан хангамж, гэрэлтүүлэг, усан сан байгуулах болон угаан баяжуулах тоног төхөөрөмж угсарч монтажлах ажлуудыг үйлдвэрлэлийн дотоод ажлын зохион байгуулалтаар хийнэ.

Хүснэгт № 2 Ил уурхайн ажлын горим

Үзүүлэлт	Х.нэгж	Хөрс хуулах	Элс олборлох
Календарь хоног	хоног	180	150
Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12	12
Ээлжийн тоо	ээлж	2	2
Сард ажиллах хоног	хоног	30	30
Баяр ёслолын хоног	хоног	3	3
Цаг агаарын саатал	хоног	4	4
Төлөвлөгөөт бус сул зогсолт	хоног	4	4
Засвар үйлчилгээ хийх өдрүүд	хоног	5	5
Бэлтгэл ажлын хоног	хоног	1	1
Зөөвөр нүүдэл хийх өдөр	хоног	5	3
Жилд ажиллах сар	сар	6	5
Жилд ажиллах хугацаа	**хоног**	**158**	**130**

Хөрс хуулалтад ажиллах цэвэр ажлын хоног 158, элс олборлолтод ажиллах ажлын цэвэр 130 хоног байна.

I.8 Хүчин чадал

Туулын зүүн дэнжийн алтны шороон ордыг ашиглах ТЭЗҮ-ийн тодотголд жилд хуулах хөрс, олборлох элсний хэмжээг “Хамтын Эх Булаг” ХХК-ийн уурхайд ашиглагдаж буй үндсэн тоног төхөөрөмжүүдийн хүчин чадал, төсөл захиалагчийн техникийн даалгаврын дагуу жил дунджаар 600.0 мян.м^3 хөрс хуулж, 25.0 мян.м^3 элс олборлон угаахаар төсөлд тусгалаа.

I.9 Инженер хангамж, дэд бүтэц бусад хэсэг

Цахилгаан хангамж: Ил уурхайн үндсэн цахилгаан хэрэглэгч болох ЭШ-10/60 маркийн алхагч экскаватор нь Дарханы цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн Өгөөмөр тосгонд байрлах 35/6кВ-ын дэд станцаас ирж байгаа 6кВ-ын өндөр хүчдэлийн агаарын шугамаас салаалуулан шууд тэжээж байна. Харин баяжуулах хэсгийн эргэлтийн усны насоснууд, СБС-1.6 маркийн угаах төхөөрөмж, ил уурхайн гэрэлтүүлэг, уурхайн тосгон, засварын газар зэрэг хэрэглэгчид нь дээрх агаарын шугаманд 6/0.4кВ-ын трансформаторын дэд станцад холбож түүнээс цахилгаан эрчим хүчээр хангаж байна.

1. Ил уурхай
2. Засварын хэсэг

3. Угаан баяжуулах хэсэг
4. Ажилчдын хотхон, контор

Дэд бүтэц: Туулын зүүн дэнж уурхайн дэргэд байрлах уурхайн тосгонд 66 хүн амьдрах кемп, халуун ус, гал тогоо, уурхайн оффис, чөлөөт цагаа өнгөрүүлэх талбай, ногооны талбай зэрэг барилга байгууламжууд мөн дэд станцууд, тэсрэх бодисын агуулах зэрэг байна.

Байгаль орчин хамгаалал, уурхайн нөхөн сэргээлт хаалт:Туулын зүүн дэнж нэртэй алтны шороон ордыг ашиглах төсөл нь байгаль орчин, нөхөн сэргээлтийн тухай Монгол улсын холбогдох хууль тогтоомж, стандартуудыг мөрдлөг болгон ажиллана.

Уурхайн хаалтын зардал нь дараах зардлуудаас бүрдэнэ. Үүнд:

- Уурхайн хаалт нөхөн сэргээлтийн шууд зардал
  - Байгаль орчин хамгаалах зардалд 20.41 сая төгрөг
  - Техникийн нөхөн сэргээлтийн зардалд 140.18сая төгрөг
  - Биологийн нөхөн сэргээлтийн зардалд 39.66 сая төгрөг
- Хаалтын дараах хяналт мониторинг, хаагдсан талбайн арчилгаа хамгаалалтын зардал 223.24 сая төгрөг

Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн нийт зардал 223.24 сая төгрөг, жилд дунджаар 55.81 сая төгрөгийг тусгасан.

Хүний нөөц:Төслийн нийт ажилчдын тоо 61 бөгөөд уурхайн удирдлагын хэсэгт 9 хүн, ил уурхайн хэсэгт 30 хүн, засвар цехийн хэсэгт 4 хүн, баяжуулах цехийн хэсэг 12 хүн, хотхоны хэсэг 6 хүн тус тус ажиллаж байна.

Усан хангамж: Судалгаагаар ордын татмын хэсэгт хамгийн их усжилттай бөгөөд бараг Туул голын түвшнээс эхлэн уст үе тогтоогдсон байна. Дэнжийн хувьд 1930 м-ийн түвшнээс эхлэн уст үе тогтоогдсон бөгөөд ундарга нь 0.33-1.2 л/с байна. Усны дээжид хийсэн хими болон бактерилогийн шинжилгээгээр хатуулаг нь 3.5-5.3 мг экв/л найрлагаараа кальцийн бүлэг, чанарын хувьд 2-р ангийн цэнгэг, өнгө, амт, үнэргүй бөгөөд ундны усны Монгол улсын MNS900:2005 чанарын стандартын шаардлагыг хангаж байгаа болохыг тодорхойлжээ. Уурхайн хэмжээнд 1.2 л/с-ийн ундаргатай шүүрлийн ус, 0.53-1.12 л/с-ийн ундаргатай гүний 2 худагтай. Дээрх усны эх үүсвэрээс унд ахуй, технологийн усаа хангаж байна.

I.10 Эдийн засгийн үр ашиг

Ордыг ашиглах төсөл нь ашиглалтын хугацаанд нийт 1314.9 сая төгрөг, жилийн дундаж цалингийн фонд 328.7 сая төгрөгийн цалингийн зардалтай ажиллах бөгөөд үүний 23 хувийг удирдлага захиргаа, 41 хувийг ил уурхай, 17 хувийг баяжуулах цех, 11 хувийг хотхон, 8 хувийг засварын цехийн ажиллах хүчний зардал тус тус эзэлнэ. Дунджаар 1 ажилтны сарын дундаж цалин 1087.0 мян.төг байна. Хувь хүний орлогын албан татварт жилд дунджаар 16.5 сая төгрөг төлөхөөр байна.

Ажиллагсдад олгох цалингийн хэмжээг тогтоохдоо ирээдүйд, цалин өсөх чиглэлийг баримталсан ба, Монголын нийгэм эдийн засгийн өнөөгийн хөгжлийн онцлог, уул уурхайн үйлдвэрлэлийн жишиг тарифыг харгалзав. Төслөөр нийтдээ

61 ажлын байр бий болох юм. Уурхайн горим ёсоор 2 ээлжээр 12 цагаар ажиллана.

II. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ СУУРЬ НӨХЦӨЛ

Уур амьсгал: Цаг агаарын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилийн дундаж хэм нь +2.8°C байдаг. Хамгийн хүйтэн сар нь 1-р сар ба агаарын хэм нь -37°C, хамгийн дулаан сар нь 7-р сар ба агаарын хэм нь +40 С хүрдэг.

Агаарын температурын сарын дундаж нь нутгийн төв хэсгээр 12-17 градус, бусад нутгаар 17-22 градус дулаан буюу ихэнх уур амьсгалын дунджаас 1.0-2.0 градусаар дулаан байх төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн эхэн, хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр ихэнх нутгаар, нэгдүгээр арав хоногийн дунд үе, хоёрдугаар арав хоногийн эхэн ба сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар түр зуурын бороо орох төлөвтэй. Дуу цахилгаантай. Борооны өмнө зарим газраар салхи түр зуур ширүүснэ. /Эх сурвалж: Булган аймгийн ус, цаг уур, орчин шинжилгээний алба/

Агаарын чанар: Нарны цацрагийн жилийн явцаас хамааран сэрүүн бүсэд жилийн дөрвөн улирал ээлжилдэг. Тухайн орон нутгийн хотгор гүдгэр, газрын гадаргын шинж зэргээс хамааран улирлын шинж газар бүр харилцан адилгүй байдаг.

Булган аймгийн уур амьсгал нь Монгол орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс шинжтэй. Энд өвөл нь хүйтэн бөгөөд удаан үргэлжилнэ. Зун нь богино, халуун болдог. Хавар, намрын улиралд цаг агаар тогтворгүй эрс өөрчлөгдөж байдаг.

Газрын доорх ус: Булган аймгийн усны нөөц 1504,8 сая.м3/жил бөгөөд зэргэлдээ орших нутгаас дамжин ирэх урсцыг тооцоолбол 9604,0 сая.м3/жил болно. Газар доорх усны ашиглалтын нөөц нь 313,5 сая м3/жил байна гэж тооцжээ. Дээрх дүнгээс харахад гадаргын ус 96,9 хувийг, газрын доорх ус 3,1 хувийг эзэлж байна.

2017 оны усны тоо бүртгэлээр 487 гол горхиноос устай 459, усгүй 28, 641 булаг шандаас устай 468, усгүй 173, 113 нуур тойрмоос устай 87, усгүй 26, 58 рашаан, рашаан төст булгаас устай 57, усгүй 1 тус тус тоологдсон. 2011 оны усны тоо бүртгэлийн дүнтэй харьцуулахад 24 гол горхи, 71 булаг шанд, 4 нуур, 2 рашаан сэргэсэн байна.

Ургамал зүй: Туулын зүүн дэнж нэртэй алтны шороон орд нь Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт байрлаж байна.Монгол орны ургамал зүйн мужлалаар Азийн цөлийн мужийн Алшаа говийн тойрогт хамаарагдаж байна. Энэ бүс нутагт жилдээ 100 мм–ээс бага хур тунадас унадаг, хуурай, халуун зун болдог, ургамал ургах дулаан хоногийн тоо их боловч хангалттай чийг өгч чаддаггүй учир өвслөг ургамлаас илүү сөөг, сөөгөнцөр ургамлууд зонхилон тохиолддог байна. Алшаа говийн тойргийн ургамалжилтын гол онцлог нь унаган /индемик/ ургамлын

төрөл зүйл бусад тойргуудаас олон зүйл ургадаг нь ихээхэн онцлог юм. Мөн ховор болон нэн ховор ургамлын төрөл зүйл ч цөөнгүй тохиолдох онцлогтой.

Тус сумын нутагт орших Хүрэн баганын нуруу, Хүрэн боомын уул, Сайрын шар уул, Гурван үнэгт, Алгийн нуруу, Дэл, Тосон Бумба, Шовон, Хиргэр, Даац, Нарийн, Цонж, Алтан, Нэмэгт, Тамгат, Зангит, Жилбэнт, Тост зэрэг томоохон уул нуруудаар чулуут сөөг, сөөгөнцөр ургамал болох Sympegma regelii, Zygophyllum xanthoxylon, Salsola laricifolia, Amygdalus mongolica, Atraphaxis frutescens, caragana stenophylla, Gymnocarpos Przewalskii, Anabasis brevifolia зэрэг ургамлууд түлхүү тохиолдоно.

Ан амьтан: Төслийн талбай орчмын амьтны аймгийн судалгааг урьд өмнө нь тусгайлан хийж байгаагүй бөгөөд ялангуяа өвлийн улиралд судалгааны талбайд ямар амьтад тохиолдох боломжтой талаарх ямар нэгэн судалгааны материал байхгүй. Харин төслийн талбайд хамгийн ойр хийгдсэн судалгааны мэдээлэл гэвэл тус сумын нутаг дэвсгэрт хийгдсэн судалгаагаар нийт 3 зүйлийн шавж идэштэн, 20 зүйлийн мэрэгч, 3 зүйлийн туулай, 1 зүйлийн гар далавчтан,9 зүйлийн мах идэштэн, 4 зүйлийн туруутан, 1 зүйлийн туурайтан буюу 7 багт хамаарагдах 40 гарын зүйлийн хөхтөн амьтад, 11 багийн 124 зүйлийн шувууд, 2багийн 7 зүйлийн мөлхөгч амьтад тэмдэглэгджээ.

Судалгааны талбайн ихэнх хэсэг бэлчээр ашиглалт, уул уурхайн үйл ажиллагаа зэрэгт өртөгдсөн тул зэрлэг амьтдын тархалт харьцангуй бага. Харин нөлөөлөлд харьцангуй бага өртөгдсөн зүүн болон зүүн хойд хэсгээр зэрлэг амьтад харьцангуй элбэг тохиолдож байв. Зэрлэг амьтдын ихэнх хувийг жижиг шувууд эзэлж, хөхтөн амьтдын хувьд жижиг хөхтөн амьтад дийлэнх хувийг эзэлж байна.

Хөрсөн бүрхэвч: Зүсэлтийн хээрийн бичиглэлээс үзэхэд ялзмагт үеийн зузаан дунджаар 0-8см, 0-12см, хөрсний өнгөн үе том жижиг чулуу маш ихтэй. Ялзмагийн хуримтлал дээд үедээ 0.65%, нийт азот хөрсний бүх үе давхаргуудад 0.03%, хөрсний орчин 8.94-9.23 буюу сулавтар шүлтлэг, харин 100г хөрсөн дэх шингээх багтаамж 22.3мг/экв байгаагийн дийлэнх хувийг кальцийн катион давамгайлж байна.Энэ хөрс үржил шим, шим тэжээлийн бодисын /азот, фосфор, калийн/ хангамжаар маш ядуу хангамжтай хүснэгт №1-ийн зүсэлт уурхайн нөхөн сэргээлт хийхэд нутгийн унаган ургамал тариалахаас гадна физиологийн хүчиллэг эрдэс бордоо 1га-д N40P60K60кг-аар шим бордоо 40кг хийж өгөх хэрэгтэй. Хөрсний цахилгаан дамжуулах шинж чанар нь шинжилгээгээр хортой биш байна. Иймд нутгийн унаган ургамлыг тариалж болно.

Дэд бүтэц нийгэм эдийн засаг: Монгол орны төв хэсэгт, Улаанбаатар хотоос 265 км, Булган аймгийн төвөөс 86 км зайд орших Бүрэгхангай сум нь 1923 онд үүсгэн байгуулагдсан. Монгол улсын төв хэсэгт оршдог дэд бүтэц зам харилцаа сайн хөгжсөн Эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон. Нийт 349792 га газар нутагтай бөгөөд Дашинчилэн, Хишиг-Өндөр, Орхон сум, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сум, Төв аймгийн Заамар сумнуудтай хиллэдэг. Газар зүйн хувьд ойт хээрийн бүсэд багтдаг бөгөөд нутгийн 8%-ийг ой, 92%-ийг тал хээрийн бүс

эзэлдэг.Орхон Туул, Ангирт, Ямаат, Бичигт, Шувуут, Харбух зэрэг томоохон гол, горхи, булаг шандтай.

Нийгэм, эдийн засгийн байдал: Сумын төсвийн нийт орлого нь 397,7 сая төгрөг, сумын өөрийн орлого 0,4 сая төгрөгийн орлогоос бүрддэг. Орон нутгийн төсвийн зардал нь 374,1 сая төгрөг ба нийт зардлын 42,2 % нь цалин, 4,9 хувь нь НДШ,46,7 хувийг урсгал шилжүүлэг 6,2 хувийг бусад зардал эзэлж байна.

Эдийн засгийн бүтэц: Сумын хэмжээнд нийт 25 ААН,байгууллага үйл ажиллагаа явуулж 9.3 тэрбум төгрөгийн бүтээгдхүүн үйлдвэрлэж улсад 5385,5 сая,аймагт 61442,7 сая, орон нутагт 397733,9 сая нийт 464552,1 сая төгрөгийнтатвар төвлөрүүлж байна.

III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Хамтын Эх Булаг” ХХК-ийн алтны шороон ордыг ашиглах явцад дараах сөрөг нөлөөлөл үзүүлэх юм.

Хүснэгт № 3 Төслөөс үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Орчин	Сөрөг нөлөөлөл	Хамрах хүрээ	Эрсдэлийн зэрэглэл
Газрын хэвлий	Алт олборлох, уурхайн барилга байгууламжаар эвдрэлд орно.	Төслийн талбайд	Их
Агаар	Олон хүний хөдөлгөөн, машин механизмын яндангаас гарах утаанаас болж агаар бохирдоно.	Төслийн талбай, түүний орчим	Дунд
Хөрсөн бүрхэвч	0.1 га талбайн хөрсөн бүрхэвч бүр мөсөн устаж, төслийн бусад талбайн хөрс элэгдэл эвдрэлд өртөнө.	Төслийн талбайд	Их
Ургамлын бүрхэвч	0.1 га талбайн ургамал бүрмөсөн устаж, төслийн бусад талбайн хөрс элэгдэл эвдрэлд өртөнө.	Төслийн талбайд	Их
Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа	Тоосжилт, ХАБЭА-н дүрэм журмыг сайн хангаагүй тохиолдолд ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлнө.	Төслийн талбайд	Бага
Ус	Газрын доорх усны түвшинд нөлөөлж улмаар нөөц багасах, хуурайших, голын усны түвшин багасах, шатахуун, шатах тослох материалын асгаралтаас ус бохирдож болзошгүй	Төслийн талбай орчим	Бага

III.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

- Машин механизмын яндангаас гарах утаа болон ахуйн хог хаягдал, олон хүний хөдөлгөөнөөс болж агаарын чанарт нөлөө үзүүлнэ.
- Ажиллагсдын агаарын чанарын стандарт, тоосжилтоос урьдчилан сэргийлэх хөдөлмөр хамгааллын хэрэгсэл ашиглах дүрэм, шаардлагыг хэрхэн мөрдөж байгаад хяналт тавих, зааварчилгаа өгөх, сургалт явуулах
- Мөн уурхайн олборлолтын үед тоос дэгдэж, агаарын чанарт сөрөг нөлөөлөл үүснэ.
- Уурхайн тээвэрлэлтийн шороон замд том оврын тээврийн хэрэгслийн нөлөөгөөр тоосжилт ихээр бий болж агаарын чанарт сөргөөр нөлөөлнө.

III.2 Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Хаягдлын аж ахуйд эргэлтийн усны систем ашиглан үйлдвэрлэлийн хаягдалтай хамт хаягдсан усыг цэвэрлэн үйлдвэрлэлд эргүүлэн хэрэглэх шаардлагатай бөгөөд орон нутгийн хөрсний шингээлт, ууршилтын тайлангүй учир бусад үйлдвэртэй харьцангуйгаар технологийн нийт хэрэгцээт усны 80%-ийг эргүүлж ашиглахаар тооцоолсон байна. Тоног төхөөрөмжүүдийн цэвэрлэгээ болон бусад хэрэгцээнд бүх технологийн усны 15-20%-ийг хэрэглэнэ.

- Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын болон газрын доорх ус бохирдож болзошгүй.

- Ахуйн хатуу, шингэн хог хаягдалдаа зөв менежмент явуулаагүйгээс болж гүний ус бактер болон химийн бохирдолд орж болзошгүй.
- Технологийн хэрэгцээндээ шаардлагатай усыг газрын доорх уснаас ашиглаж байгаа тул газрын доорх усны нөөц баялаг багасах
- Ахуйн бохир хаягдал гадаргын болон газрын доорх усыг бохирдуулж болзошгүй.
- Уурхайн техник хэрэгсэлд ашиглагдах шатах тослох материал алдагдсанаас болж хөрсөн бүрхэвч хүнд металлаар бохирдож улмаар гүний усанд нэвчих

III.3 Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

- Хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлын нөмрөг шороонд дарагдах зэргээр эвдрэлд орно.
- Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлын нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг, бүрхэц арви багсана.
- Уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсэж тоосжилт үүсгэх
- Газрын гадарга хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдож болзошгүй
- Уг төсөл хэрэгжсэнээр тухайн төслийн талбай түүний орчмын бэлчээрийн талбай хомсодно.
- Хөрс хуулалт болон шимт хөрсийг хадгалах явцад хөрсний үржил шим нь алдагдах
- Машин техник, хүний нөлөөллөөр төслийн талбай түүний орчмын ургамлын зүйл устгаж үгүй болж оронд нь хөл газрын ургамлын зүйл түрэн ургаж болзошгүй.

III.4 Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

- Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, мөн хөрс хуулалтын үйл ажиллагаанаас хөрсөн дэх макро, микро бичил амьтад үхэж хорогдох зэрэг нөлөөллүүд үүснэ.
- Зэрлэг амьтан уурхайн дуу чимээнээс зугтан дайжиж, ан амьтан ухсан нүх сувагт унаж бэртэх зэрэг үр дагавар гарч болзошгүй тул булах ажлыг байнга хийнэ.
- Тус ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас амьтны зүйлд үзүүлэх шууд нөлөөлөл харьцангуй бага бөгөөд харин тус байгууламжийн бүтээн байгуулалтын үед хөрсөнд болон хөрсөн дээр

амьдардаг хорхой шавж газар шорооны ажлын үед устах хөрстэй хамт зөөгдөх, дайжин алга болж болзошгүй.

- Тоосжилтоос үүдэн төслийн талбай түүний орчмын хөрс, ургамлын нөмрөг тоосонд дарагдаж ингэснээр амьтадын зүйлийн идэш тэжээлд дам байдлаар сөрөг нөлөөлөл үзүүлэх талтай.
- Хөрс, ургамлын нөмрөгт төслийн үйл ажиллагаанаас бохирдол үүсвэл тухайн ургамал, хөрснөөс хоол тэжээлээ олж иддэг амьтдын зүйлд дам байдлаар сөргөөр нөлөөлж амьтны зүйл хордож, үхэж үрэгдэж болзошгүй.
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, олборлолт явуулахад газар шорооны ажил хийгдэж тоосжилт үүсэж ургамлын нөмрөг тоосонд дарагдана.

IV. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ГОЛ ЗОРИЛТ

“Хамтын эх булаг” ХХК нь Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн А-05 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу “Туулын зүүн дэнж” алтны шороон ордны 2019 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

“Туулын зүүн дэнж” алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож , хариуцах эзэн , хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгалаа.

“Туулын зүүн дэнж” алтны шороон ордын 2024 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тусгалаа.

Алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг байгаль хамгаалах хууль тогтоомж, байгаль орчны нарийвчилсан үнэлгээний үр дүн, батлагдсан орчны менежментийн төлөвлөгөө /5/-нд үндэслэн, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлалын 4-р хэсгийг баримтлан боловсруулав.

IV.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмжийг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов.

Хүснэгт № 4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Цар хүрээ, хэмжээ	Нэгжийн өртөг (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаар орчин							
1	Уурхайн олборлолт болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд: Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, бутлалт овоолго зэрэг газар шорооны ажил Ажилчдын суурин болон уурхайн олборлолтын үеийн газар шорооны ажил	Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдэд Монгол Улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд (MNS 5013:2003 бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид) болон олон улсын холбогдох стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж түүнд нийцүүлнэ.	Төсөлд ашиглагдах 4 техник тоног төхөөрөмжид	4*40.0 =160.0	160.0	Олборлолтод гарахын өмнө	-Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, -MNS4585:2007 (Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага) -MNS3383:1982 (Агаар мандал, Бохирдлын эх үүсвэр, нөхцөл байдал ба тодорхойлолт) -MNS5885:2008 (Агаар бохирдуулагч бодисуудын хүлээн зөвшөөрөгдсөн концентраци, Техникийн ерөнхий шаардлага) MNS4225:2011
		Уурхайн машин механизмуудын янданд шүүлтүүр тавина /TWCAT002,TWCAT0061 маркийн шүүлтүүр/	Төсөлд ашиглагдах 4 техник тоног төхөөрөмжид	4 * 40,0 = 160.0	160.0	Олборлолтод гарахын өмнө	
		Олборлолтын ажлын үед газар шорооны ажлыг аль болохоор бага хэмжээтэй хязгаартай хийнэ	Уулын ажлын үед		-“-	Төслийн бүх үе шатанд	

	Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, Тээвэрлэлтэд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох	Хучилтгүй зам дээр тээвэр хийх машины хурдыг хязгаарлана	Уурхайн зам болон орон нутгийн зам		-“-	Төслийн бүх үе шатанд	(Агаарын чанар, Ерөнхий танилцуулга) -MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) -Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 -Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003 MNS5010-2001, “ХАБЭА. Ажлын байран дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага”
		Машинаас гарах тоос шороог багасгах үүднээс хучилтгүй замын гадаргыг шаардлагатай хэсгүүдэд засна (олборлолтын ажлаас өмнө)	Уурхайн зам	Үйл ажиллагааны зардалд тусгана.		Төслийн бүх үе шатанд	
		Тоосжилтыг дарах зорилгоор авто зам, уурхайн карьерын мөргөцөг, шимт хөрсний овоолгын тоосжилтоос хамгаалах усалгаанд ус ашигласны төлбөр	Уурхайн зам, карьерын мөргөцөг, овоолго			Төсөл хэрэгжих хугацаанд	
2	Уурхайлалт, олборлолт, техник тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны улмаас дуу чимээ ихээр үүсэж ажилчид болон нутгийн иргэд дуу чимээний бохирдолд орох	Зам харгуйг засварлан сайжруулж тэмдэгжүүлнэ	Уурхайн болон орон нутгийн замд	150.0	150.0	Төсөл хэрэгжих хугацаанд	-MNS ISO 226:2003 дуу чимээ-хэвийн норм-түвшний хэмжээ
		Олборлолтын ажлыг өдрийн цагаар гүйцэтгэнэ.	Уурхай дотор		-“-	Төлөвлөлт, олборлолтын ажлын үе шатанд	
		Дуу шуугианы хэмжилт (1 цэгт дууны түвшин хэмжигч NL-04 багажаар) хийж, дуу, шуугиан бүхий машин механизмын ашиглалтыг оновчтой төлөвлөх, үр ашиггүй ашиглалтыг багасгана. Уг багажийг хэрэв БОТЛ-аас түрээсэлбэл түрээсийн зардал нэг удаа 25000 төг	Лицензийн талбайд	25.0 төг *2 цэгт = 50.0	50.0	Жилд нэг удаа дууны түвшин хэмжигч NL-04 багажаар хэмжилтийг хийнэ.	
Усны нөөц, чанар							
3	Гадаргын усыг авч ашигласнаар голын урсцын	ШТМ-ын агуулахын орчмыг хатуу хучилттай болгоно.	ШТМ-ын агуулах болон түүний орчим	550.0	550.0	Төлөвлөлт, олборлолтын ажлын үе шатанд	-Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль

	горим алдагдах, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамжилтанд сөргөөр нөлөөлж болзошгүй.	Уурхайн олборлолтын ажлын явцад орчны тоосжилтыг бууруулахад газар доорх усны нөөцийг аль болох ашиглахаас зайлсхийж, цэвэршүүлсэн ахуйн хаягдал усыг эргүүлж ашиглана.	Лицензийн талбайд	600.0	600.0	Төлөвлөлт, олборлолтын ажлын үе шатанд	-ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт-Ус ашигласны төлбөрийн хувь хэмжээ
Хөрс, ургамлын бүрхэвч							
4	Уурхайн ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал тоосжилтоос бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх, ШТМ, барилгын материалын хог хаягдал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол авараас	Уурхайн орчны авто замд тэмдэгжүүлэх ажил хийх, олон салаа зам гаргахаас сэргийлнэ.	Төсөл хэрэгжих талбай болон түүний орчим	Үйл ажиллагааны зардалд тусгана.		Төслийн эхэнд	-Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойолох арга, -MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
		Ил уурхай болон газар эвдэх бусад үйл ажиллагаануудыг эхлүүлэхээс өмнө өнгөн хөрсийг хуулан авах. Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон түүний явцад хуулан авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгална.	Төсөл хэрэгжих талбайд			Төлөвлөлт, олборлолтын ажлын үе шатанд	
		Хог хаягдлыг тээвэрлэж зайлуулна.	Орон нутагтай хамтран гэрээгээр зайлуулна.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.		Тухай бүрд	
		ШТМ-ын хадгалалтад хяналт тавина.	ШТМ-ын агуулахад	Үйл ажиллагааны зардал тусгана.		Тухай бүрд	
		Олборлолтын ажил, түүний овоолго, тээвэрлэлт нь тус талбайн хөрсний эвдрэлийг аль болох бага байлгахад чиглэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тухайн тогтоогдсон	Уулын ажил		-“-	Төсөл хэрэгжих явцад	

	үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	ажлын зурваст байлгах арга хэмжээ авах					
Амьтны аймаг							
5	Ухсан нүх, карьерт амьтад орж үрэгдэх, дуу чимээний нөлөөллөөс үргэж дайжих	Уурхайн бүсэд хамгаалалтын хашаа барих, шувууны үүр барьж өгөх	Лицензийн талбайн ойр орчим болон орон нутагт	500.0	500.0	Төслийн эхэнд	Амьтны тухай хууль
Хөндлөнгийн хяналт							
6	Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгаа	Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааг 2 жил тутамд хийлгэнэ.	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	3000.0	3000.0	2024 онд	
Нийт зардал				**5170.0**	**5170.0**		

IV.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Уулын ажил явагдсан нутаг дэвсгэрийн физик газарзүйн нөхцөл, геоморфологийн тогтоц, нутаг дэвсгэрийн болон технологийн онцлогоос хамаарч нөхөн сэргээлтийн ажлыг цаашид бэлчээрийн зориулалтаар ашиглах шаардлагыг хангах хэмжээнд хүртэл гүйцэтгэнэ. Нөхөн сэргээлтэд ашиглалтын явцад эвдрэлд орох талбайнуудыг аль болох сэргээж байгалийн унаган төрхөд нь ойртуулан засах зорилт тавигдана.

Олборлолт ажил явагдсан нутаг дэвсгэрийн физик газарзүйн нөхцөл, геоморфологийн тогтоц, нутаг дэвсгэрийн болон технологийн онцлогоос хамаарч нөхөн сэргээлтийн ажлыг цаашид бэлчээрийн зориулалтаар ашиглах шаардлагыг хангах хэмжээнд хүртэл гүйцэтгэнэ. Нөхөн сэргээлтэд ашиглалтын явцад эвдрэлд орох талбайнуудыг аль болох сэргээж байгалийн унаган төрхөд нь ойртуулан засах зорилт тавигдана. Уурхайн хотхоныг тойроод навчит ургамлаар нөхөн сэргээлт хийнэ.Нийт 1.2 га талбайд нөхөн сэргээлт хийнэ. Үүнээс уурхайн хотхон дотор 0,5 га, олон наст ургамал 0.3 га, тэр бум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 0,4 га талбайд тус тус нөхөн сэргээлт хийнэ.

Хүснэгт № 5 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Зардлын утга	Хэмжих нэгж	Ажлын хэмжээ	Тоо, ш	Модны үнэ, төг
Биологийн нөхөн сэргээлтийн ажлын зардал					
1	Хайлаас	га	1	100	550 000
2	Шар хуайс	га	1	80	320 000
Олон наст , кг					
1	Согоовор	га	0.2	8	200 000
2	Шар хуайс	га	0.1	6	150 000
Нийт		**га**	**0.8**		**1 220 000.0 төг**

IV.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнд хууль бус ан агнуурыг багасгах, зэрлэг ан амьтдын усан хангамжийг сайжруулах, ургамлан нөмрөгийг нөхөн сэргээж нэмэлт арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгалаа.

Хүснэгт № 6 Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт өртөг /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт
Хууль бус ан агнуурыг багасгах	Уурхайн ажилчдыг хууль бус ан хийлгэхгүй байх	Бүрэгхангай сумын хэмжээнд	-	-	Улиралд 1 удаа	Мониторинг судалгааны арга зүйн дагуу, мөн Монгол улсад мөрдөгдөж буй байгаль орчны хууль тогтоомж, бусад холбогдох хуулийн хүрээнд
	Сум орон нутгийн удирдлага, байгаль орчны хүмүүс, цагдаа гэх мэт орон нутгийн ард иргэдтэй хамтран хууль бус ан агнуурыг зогсоох, холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулах, хамтарсан эргүүл шалгалтыг зохион байгуулна.		-	400.0		
Чимээ шуугиан, шөнийн гэрлийн	Шаардлагатай тохиолдолд шөнийн цагаар автомашинаар явахгүй, гэрэл	Уурхайн хүрээнд	Үйл ажиллагааны зардалд		Үйл ажиллагааны туршид	

нөлөөгөөр ан амьтан үргэх	асаахгүй байх арга хэмжээ авна. Уурхайд хэрэглэгдэх тоног төхөөрөмжийг стандартад заасны дагуу суурилуулж бэхэлнэ.					
Бүрэгхангай сумын төвлөрсөн хогийн цэгийг түрж тэгшлэх	Дүйцүүлэн хамгаалах ажлыг орон нутгийн удирдлагуудтай хамтран ажиллахаар тохирсон байгаа.	Орон нутгийн удирдлага, уурхай	500			Хог хаягдлын тухай хууль
Нийт зардал			**900.0**			

IV.4 Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Тухайн төслийн үйлдвэрлэлийн болон эрчимтэй нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

IV.5 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Туулын зүүн дэнж нэртэй алтны шороон орд төслийн барилга байгууламжуудыг барьж байгуулах, тэдгээрийг ашиглахад Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг дэвсгэрт буй улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудад шууд сөрөг нөлөөлөл байхгүй. Төслийн талбайд барилга байгууламжуудыг барьж байгуулах, төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17.11-ийн дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй.

IV.6 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт № 7 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад үүсэж болзошгүй ослын менежментийн төлөвлөгөө						

Уурхайн үйл ажиллагааны явцад хатуу, шингэн хаягдлыг тогтоосон хугацаанд зайлуулахгүй удаан хугацаагаар хуримтлуулан хадгалах, ил задгай байлгах, бохирдуулснаас цооног халих, хог хаягдлын цэг, жорлон, бохир усны цооногт тогтоосон хугацаанд ариутгал хийхгүй байх, хоол хүнсний хаягдлыг таггүй саванд ил хадгалах зэргээс орчны ус, хөрс, агаар бохирдож, халдварт өвчний нян үүсэж үржих, халдварт өвчин үүсэн тархах нөхцөлтэй.	Үйлдвэрийн хэмжээнд онцгой байдал, ослын үед хэрэгжүүлэх арга хэмжээний тусгай төлөвлөгөөтэй ажиллана. Осол аваар гарсан үед түүний хугацаа, байршил, төрөл хэлбэр, хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулах сөрөг нөлөөлөл, хамрах цар хүрээг тогтоосны үндсэн дээр шаардагдах хүн хүч, хөрөнгө зардлыг тодорхойлж, ослын үр дагаврыг яаралтай арилгах болон цэвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Ослын хор уршгийг арилгасны дараа түүний бүрэн арилсан эсэхэд судалгаа хийж, хяналт тавьж ажиллана.	Уурхайн ажилчид		Урьдчилан тооцох боломжгүй.	2024 онд	Гамшгаас хамгаалах тухай хууль,
	Ажиллагсдыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Уурхайн хэмжээнд	1000.0		Жилд 2 удаа	
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй	Барилга			Өдөр бүр,	MNS 5566:2005, Аж ахуйн нэгж байгууллагад зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн шаардлага, MNS 5390:2004, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS GOST R12.2.143:2013, Гал түймрийн үед нүүлгэн шилжүүлэх гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ, ангилал. Техникийн шаардлага. Хяналтын аргууд Барилга, байгууламжийн зураг
	Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулна.					
	Уурхайн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулж, хамруулна					
	Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулна.	Уурхайн бүх ажилчдад	100.0	500.0	Жилд 2 удаа	
	Уурхайн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулж, хамруулна.	Уурхайн бүх ажилчдад				

	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллана.	Уурхайн бүх ажилчид				
	Гал унтраах хэрэгслээр уурхайг бүрэн хангаж арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулна.					
	Ажилчдыг ажлын хувцас хэрэгслээр бүрэн хангана.					
Хяналтаас гадуурх тэсэлгээ Хяналттай тэсэлгээ нь уурхайн ашиглалтын үйл ажиллагааны нэг хэсэг бөгөөд үүнийг зөвхөн мэргэшсэн ажилчид гүйцэтгэнэ. Хэдийгээр гарах магадлал багатай ч тэсрэх бодисыг буруу ашигласнаас үүдэн хяналтаас гадуур тэсэлгээ гарч болно. Түүнчлэн зохих хэмжээнд нэг дор төвлөрүүлэн хураасан шатах шингэн буюу хий (дизель түлш, бензин) дэлбэрч болзошгүй юм.	Бусад уул уурхайн үйл ажиллагаанд гарч буй иймэрхүү осол аваарын давтамжийг харьцуулан тооцоход ослын тохиолдол маш бага байдаг. Гэвч хүний амь нас эрсдэх, тодорхойгүй урт хугацаагаар үйл ажиллагаа тасалдах зэрэг байдлаар хор уршиг ихтэй тул хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг нарийн баримтлан ажиллах	Уурхай болон түүний орчимд	Урьдчилан тооцох боломжгүй.			MNS 4990:2000. Ажлын байрны эрүүл ахуй ба хөдөлмөр хамгаалал. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 5002:2000 Ажлын байрны эрүүл ахуй ба хөдөлмөр хамгаалал. Дуу чимээний нормд тавигдах ерөнхий шаардлага ба аюулгүй ажиллах аргачлал MNS 5003:2000 Ажлын байрны эрүүл ахуй ба хөдөлмөр хамгаалал. Дуу чимээ хэмжих ерөнхий шаардлага
Нийт				**1500.0**		

IV.7 Хатуу хог хаягдлын менежмент

“Туулын зүүн дэнж”-ийн алтны шороон ордын уурхайн ашиглалтын 2024 онд гарсан хог хаягдлыг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журам стандартыг мөрдлөг болгон ажиллаж уурхайн өдөр тутмын үйл ажиллагаанаас гарч байгаа аюулгүй болон аюултай хог хаягдлыг бүртгэж ажиллахаар төлөвлөсөн байна. Мөн уурхайн өдөр тутмын үйл ажиллагаанаас гарах дахин ашиглагдах хог хаягдлыг ангилж дахин боловсруулалт хийдэг хувь хүн, аж ахуй нэгж байгууллагад нийлүүлэхээр төлөвлөсөн. Уурхайн ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг уурхайн нэгдсэн цэгт төвлөрүүлж Бүрэгхангай сумын хогийн нэгдсэн цэгт тээвэрлэнэ. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд жилд 500000 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт № 8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын талаар хийгдэх ажлууд	Хариуцах этгээн	Зарцуулагдах зардал мян.төг 2024 он	Шалгуур үзүүлэлт
1	Ахуйн шингэн болон хатуу хог хаягдал хаях цэгээ Бүрэгхангай сумын засаг даргаар тогтоолгоно.	Компанийн захирал		Бүрэгхангай сумын засаг даргын захирамж байна.
2	Ахуйн хог хаягдлаа эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлүүлнэ.		Төлбөр нь уурхайн үйл ажиллагааны зардалд орсон	Гэрээ байна.
3	Хог хаягдлын төлбөрөө төлнө.		Төлбөр нь уурхайн үйл ажиллагааны зардалд орсон	Төлбөр төлсөн баримт байна.
4	Хатуу хог хаягдлын хэмжээг тогтоож Бүрэгхангай суманд сар тутамд мэдээлж байна.	Уурхайн дарга		Уурхайд 66 хүн ажиллах бөгөөд сард ойролцоогоор 10,5 кг хатуу хаягдал гарна.
5	Уурхайн засварын цехээс гарах ашигласан тос маслыг эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.			Хог хаягдлын журнал хөтөлж явна.
6	Шингэн хаягдал хөрс болон гүний усыг бохирдуулж байгаа эсэхийг шалгаж биологийн болон химийн шинжилгээ хийлгэнэ.			Хяналт шинжилгээний хөтөлбөрт зардал нь тусгагдсан.
7	Зуны улиралд хогийн сав болон ажилчдын амьдрах байр, гал тогоонд хортон шавжийн ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх		400.0	Булган аймгийн гоц халдвартын төвөөр хийлгэх
8	Ахуйн бохир ариутгах, халдваргүйжүүлэх, задлах бодис худалдаж авах зардал		100.0	Зардлын задаргааг доор оруулав.
Нийт зардал мян.төг			**500.0**	

Хатуу хог хаягдал тээвэрлэх зардалд жилд нийтдээ **500.0 мян.төг** тусгаж байна.

IV.8 Химийн бодис эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Тус төсөл нь химийн бодис ашиглахгүй бөгөөд байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланд химийн бодисын эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй болно. Тиймээс химийн бодисын менежментийн төлөвлөгөө хийгдэх шаардлагагүй гэж үзэж байна.

IV.9 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцан ажиллана.

Хүснэгт № 9 Тухайн жилийн БОМТ хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, төг	Хариуцагч
1.	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 2 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулсан.	4, 9 саруудад	500,0 мян.төг х 2 удаа =1000,0 мян.төг	Уурхайн дарга
2	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг зохион байгуулсан бөгөөд тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгасан.	Төслийн хугацаанд	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах зардалд тусгагдсан	“Хамтын эх булаг” ХХК
Дүн			**1,000.0**	

IV.10 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт № 10 БОМТ хэрэгжилтийг тайлангах хуваарь, зардлын задаргаа

Хугацаа	Нөлөөлөлд өртөгч оршин суугчдад танилцуулах ажил	Зардал	Зохион байгуулах хүний албан тушаал
2024.06 сар	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжлийн газар дээр нь танилцуулсан	20-30 хүний суудалтай бага оврын автобус хөлсөлнө. Автобусны 1 өдрийн хөлс 150 000 төг. 1 хүний өдрийн хоол 10000төг. 30*10000=300000төг 150000+300000=450000	Уурхайн дарга болон компанийн захирал

2024.11 сар	Бүрэгхангай сумын ЗДТГ-ын мэргэжилтнүүдэд танилцуулж санал авсан	ЗДТГ-ийн хурлын танхимд төлөвлөгөөг танилцуулна. Тараах материал, зарлалын самбарын зардалд 200000 төг. Танилцуулгад хүрэлцэн ирсэн иргэдэд өдрийн цайнд 180000 төг төсөвлөлөө. 200000+180000=380000төг	Уурхайн дарга болон компанийн захирал
	Нийт зардал	**830 000.0 төг**	

V. 2024 ОНЫ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт № 11 Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал

№	Хяналт шинжилгээний дээж	Сөрөг нөлөөллийн хяналт шинжилгээний үзүүлэлт	Хяналт шинжилгээний хэлбэр, зардал	Хяналт шинжилгээ явуулах хугацаа	Хяналт шинжилгээ явуулах байршил	Хяналт шинжилгээ хийх багаж, холбогдох стандарт
1	Агаар	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, NO_2, SO_2 CO -ын агууламж, Агаар орчны бохирдол	Агаарын шинжилгээг жилд нэг удаа хэмжилт хийлгэнэ. шинжилгээний хөлс 80 000 төг.	7 сард	Уурхайн ажилчдын хотхон	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар- хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010,
2	Ус	Усны ерөнхий химийн шинжилгээ, бактерилогийн шинжилгээ (pH, EC, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, pH, цахилгаан дамжуулах чанар,	Ундны уснаас /Байдраг голоос/ жилд 2 удаа дээжлэлт авч шинжлүүлнэ. Усны ерөнхий химийн шинжилгээний нэгжийн үнэ 45000 төг, 1цэг*2 удаа*45000= 90 000 төг	7,11сарууд ад	Ундны усны худаг	Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005,
3	Хөрс	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Хүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	1. Хөрсний хяналт шинжилгээний 2 цэгт жилд 1 удаа Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг 25.0 мян.төг[1] Хөрсний хүнд металл шинжилгээний үнэ 45.0 мян.төг 2 цэг* 1 удаа* 70000төг = 140000төг	7 сард	Баяжуулах үйлдвэрийн дэргэдээс, уурхайн тосгон орчимд	- MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл - MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох - MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам - MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх
4	**Нийт**		**310.000**			

VI. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ

Хүснэгт № 12 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зрдлын нэгдсэн хүснэгт

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулагдсан нийт зардал мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	5170.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1220.0
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах	900.0
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1500.0
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	500.0
7	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1000.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	310.0
9	БОМТ-г нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	830.0
Дүн		**11430.0**

“Хамтын эх булаг” ХХК нь 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 11430.0 төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа мөнгө болгож 5715.0 төгрөгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9,15 дахь заалтад зааснаар Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулна.